



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар сарын 18-ны  
өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 450

#### ХООЛНЫ ЗАРДЛЫН НОРМАТИВ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 40.2, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15.1, 15.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр, 24 цагаар ажилладаг, сувиллын болон тусгай цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 3600 (гурван мянга зургаан зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 900 (есөн зуун) төгрөгөөр, ерөнхий боловсролын тусгай сургуулийн нэг хүүхдийн үдийн хоолны зардлыг 2400 (хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай.

4. Нэг хүүхэдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, зайлшгүй шаардлагатай илчлэг, шим тэжээлийн шаардлагыг хангасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй хүнсний бүтээгдэхүүн бэлдэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү)-т үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолын 1, 2, 4 дэх заалт, 3 дахь заалтын “Ерөнхий боловсролын сургууль...” гэснийг, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 162 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, соёл, шинжлэх  
ухаан, спортын сайд

Ё.БААТАРБИЛЭГ